



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/64

Шивээговь сум

Гэрэлтүүлгийн ажилд хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын Соёлын төвийн соёл урлагийн арга хэмжээ болон тайз гадна талбайн гэрэлтүүлэг, чимэглэл хийх ажилд 1,915,000 (нэг сая есөн зуун арван таван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Гэрэлтүүлэг, чимэглэлийн ажилд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх ажилд зарцуулагдах 1,915,000 (нэг сая есөн зуун арван таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох ажлыг зохион байгуулж, анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Соёлын төвийн дарга (Э.Төрмандах)-д, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), нярав (Б.Мөнхцэцэг) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын
2022 оны 03-р сарын 06-ны
өдрийн 1164 дугаар захирамжийн ...-р хавсралт



СОЁЛЫН ТӨВИЙН ГАДНА ГЭРЭЛТҮҮЛЭГИЙН ТӨСӨВ

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж, тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Туузан гэрэл	250 м	4500	1.125.000
2	Тогны залгуур	1 ш	5000	5000
3	Тогтоогч зам	150 м	1500	225.000
4	Гадна хананы гэрэл	4ш	65.000	260.000
5	Гадна талбайн гэрэл /паржуктар/	4 ш	75.000	300.000
6	Нийт			1.915.000